# Ард капитал групп

## ДАНС НЭЭХ ГЭРЭЭ

______ *оны* ___ *- р сарын* ___ *ны өдөр* *Улаанбаатар хот*

Энэхүү гэрээг нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити центр, 1003 тоот хаягаар үнэт цаасны мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг “Ард капитал групп” ХХКомпанийг ( РД: 5183855, УБД: 9011125147) төлөөлж Болд овогтой Өлзийбаяр / цаашид Брокер гэх / , нөгөө талаас ........................................................................................................................................ хаягаар ........................................ үйл ажиллагаа явуулдаг “......................................” ХХКомпанийг ( РД:__________, УБД: ____________ ) төлөөлж ......................... овогтой ......................... / цаашид Харилцагч гэх / нар харилцан зөвшилцөж дор дурьдсан нөхцөлтэйгээр энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Ерөнхий нөхцөл

1.1 Энэхүү гэрээгээр харилцагч гадаадын бирж дээр бүртгэлтэй үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбогдуулан брокерын компанид данс нээх болон тухайн дансаар хийгдэх гүйлгээнд оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.

### Хоёр. Данс нээх, бүрдүүлэх материал

2.1 Брокер нь харилцагчийн дансыг энэхүү гэрээний дагуу шууд нээх бөгөөд харилцагч дор дурьдсан материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- 2.1.1 Брокерт хаягласан данс нээлгэх хүсэлт албан бичгээр гаргах;
- 2.1.2 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээний баталгаажсан хуулбар;
- 2.1.3 Дансан дахь хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээд, албан тушаалтны овог нэр, төлбөр тооцооны баримтанд зурах нотариатаар гэрчлэгдсэн гарын үсгийн маягт / Брокерын баталсан хэвлэмэл маягтын дагуу дагуу гарын үсгийн баталгааг гаргаж өгнө/;
- 2.1.4 Хуулийн этгээдийн данс дахь хөрөнгийг захиран зарцуулах этгээдийг томилсон тухай /Төлөөлөн Удирдах Зөвлөл эсвэл Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр/;
- 2.1.5 Данс захиран зарцуулагчийн иргэний үнэмлэх, хуулбарын хамт (Нотариатаар батлуулсан байх).

## Гурав. Харилцагчийн эрх, үүрэг

3.1 Харилцагч дор дурьдсан эрхтэй. Үүнд:

3.1.1 өөрийн дансны гүйлгээний талаарх мэдээллийг лавлаж, дансны хуулга гаргуулан авах;
3.1.2 дансыг дундаа хамтран өмчлөх, итгэмжлэл олгох, өвлүүлэх, гэрээслэх, бэлэглэх;
3.1.3 брокерийн захиалгын журмын дагуу захиалга өгөх.

3.2 Харилцагч дор дурьдсан үүрэгтэй. Үүнд:

3.2.1 үнэт цаасны данс нээлгэхдээ шаардлагатай мэдээллийг үнэн зөв, гаргацтай, алдаагүй бичих;
3.2.2 үнэт цаасны данс нээлгэх, худалдах болон худалдан авах гүйлгээ хийх зэрэг данс захиран зарцуулахтай холбоотой хийгдэж буй гүйлгээ, ажил үйлчилгээний төлбөр, шимтгэлүүдийг саадгүй төлөх;
3.2.3 үнэт цаасны данс эзэмшигчийн энэхүү гэрээний А1 маягтад дурьдагдсан ерөнхий мэдээлэл /утас, цахим шуудангийн хаяг, аж ахуйн нэгжийн регистрийн дугаар, хаяг, эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн гэх мэт/-д өөрчлөлт орсон тухай бүрт ажлын нэг хоногийн дотор Брокерт мэдэгдэж зохих өөрчлөлтийг оруулах;
3.2.4 зөвхөн өөрийн эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсгээр баталгаажсан баримтаар гүйлгээ гүйцэтгэх;
3.2.5 харилцагч дансандаа бэлэн мөнгө байршуулах болон данснаас зарлага хийхтэй холбогдох банк хоорондын дотоод болон гадаад шилжүүлэгийн хураамжийг өөрөө хариуцаж төлөх;
3.2.6 дансанд мөнгө байршуулах болон мөнгө зарлагдахтай холбогдох валют хооронд хөрвөх аливаа ханшны эрсдэлийг харилцагч өөрөө хүлээх;
3.2.7 банк хоорондын шилжүүлэгт шаардагдах хугацааг тооцоолсоны үндсэн дээр харилцагч захиалга өгөх үүрэгтэй.
3.2.8 харилцагч нь Брокероос хүргүүлсэн дансны хуулгыг нягтлан тулгаж, хянаж байх үүрэгтэй.
3.2.9 Харилцагчийн эзэмшиж байгаа үнэт цаасны арилжааны бус бусад үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэх үүрэгтэй /биет үнэт цаасыг цахим хэлбэрт шилжүүлэн хадгалах, компанийн үйл явдал буюу corporate actions гэх мэт/

## Дөрөв. Брокерийн эрх, үүрэг

4.1 Брокер дор дурьдсан эрхтэй. Үүнд:

4.1.1 харилцагчийн өгсөн мэдээлийн үнэн зөв эсэхийг хянан шалгах, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл гаргуулан авах;
4.1.2 сэжигтэй гэж үзсэн гүйлгээг гүйцэтгэхгүй байх;

4.1.3 харилцагчийн брокерийн дансанд шилжин орсон мөнгөн дүнд үндэслэн захиалга авч гүйлгээ хийх.

4.2 Брокер дор дурьдсан үүрэгтэй. Үүнд:

4.2.1 харилцагчийн дансанд хийгдэх гүйлгээний нууцыг хадгалж, гүйлгээг цаг хугацаанд нь түргэн шуурхай хийх;
4.2.2 дансанд гүйлгээ хийгдсэний дараа харилцагчид арилжааны дансны хуулгыг цаг тухай бүрд нь хүргэх;
4.2.3 хөрөнгө оруулсан үнэт цаасны тухай мэдээллийг харилцагчийн өөрийн хүсэлтэд үндэслэн нэмэлтээр хүргэх;
4.2.3 зөвхөн харилцагчийн эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зөвшөөрлөөр дансны гүйлгээг гүйцэтгэх.
4.2.4 үнэт цаасны данс нээх, хаах, арилжааны захиалга өгөх болон мөнгөн болон аливаа гүйлгээний шимтгэлтэй холбогдолтой журмуудыг харилцагчид танилцуулах;
4.2.5 энэхүү гэрээний 4.2.4-т тусгагдсан дүрэм журманд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 2 хоногийн дотор мэдэгдэх.

## Тав. Талуудын хүлээх хариуцлага

5.1 Брокер өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас харилцагчийн мөнгөн хөрөнгө болон үнэт цаасны гүйлгээг саатулсан, хугацаа хожимдуулснаас харилцагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.

5.2 Харилцагч өөрийн гарын үсгээр баталгаажсан захиалгаас үүдэн учирч болох аливаа эрсдэл, алдагдлыг бүрэн хариуцана.

5.3 Харилцагч энэхүү гэрээний 3.2.3–т тусгагдсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг заасан хугацаанд брокерт өгөөгүйгээс учирч болох эрсдэл, алдагдлыг өөрөө бүрэн хүлээнэ.

5.4 Харилцагч банк хоорондын гүйлгээний хугацааг буруу тооцоолсон болон банкны буруутай үйл ажиллагаанаас хамааран товлосон хугацаандаа дансандаа бэлэн мөнгө байршуулж чадаагүйгээс захиалга хоцрохтой холбоотой эрсдэлийг өөрөө хариуцна.

## Зургаа. Бусад

6.1 Дансны бэлэн мөнгөний үлдэгдэлд хүү тооцохгүй болохыг талууд харилцан хүлээн зөвшөөрсөн болно.

6.2 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү гэрээний адил бичгээр үйлдэж, гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.

6.3 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд зөвшилцөлд хүргэж шийдвэрлэх ба үл зөвшилцөлд хүрвэл шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| Брокерыг төлөөлж: | Харилцагчийг төлөөлж: |
| “Ард капитал групп ” ХХК | “.................................” ХХК |
| Гүйцэтгэх Захирал | ................................. |
| ___________________________ | ___________________________ |
| */гарын үсэг/* | */гарын үсэг/* |
| *тэмдэг* | *тэмдэг* |

## ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

*Иргэн* ☐ *Хуулийн этгээд* ☐

. . . . . оны . . . сарын . . . -ны өдөр . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . аймаг/хот

**Данс захиран зарцуулагч:**

Данс захиран зарцуулах хүний овог, нэр: ............................... овогтой ..............................

Улсын харъяалал: .....................................

Иргэний үнэмлэхийн дугаар: .....................................

Регистрийн дугаар: .....................................

Эрхэлсэн ажил: .............................................................................

Ажлын газрын хаяг: .............................................................................

Ажлын утас: .....................................

Оршин суугаа байнгын хаяг: .............................................................................

.............................................................................

Гэрийн утас: .....................................

Гар утас: .....................................

E-mail хаяг: .............................................................................

**Хуулийн этгээд:**

Оноосон нэр: .............................................................................

Улсын бүртгэлийн дугаар: ....................................

Регистрийн дугаар: ....................................

Үндсэн үйл ажиллагаа: .............................................................................

Хаяг: .............................................................................

Утас: ....................................

Факс: ....................................

# Ард капитал групп

E-mail хаяг: ..............................................................................

ХАРИЛЦАГЧ: ............................ /Гарын үсэг/ БДК-ИЙН АЖИЛТАН: ............................ /Гарын үсэг/

ХАРИЛЦАГЧИЙН ДАНСНЫ ГАРЫН ҮСГИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
SIGNATURE FORM OF ACCOUNTHOLDER / Legal Entity /

200 . . . оны . . . сарын . . . өдөр
Day Month Year

<table>
<tr><td colspan="2">Брокерийн компани дахь дансны дугаар<br>Account Number</td><td>Байгууллагын нэр/ Company’s name:</td></tr>
<tr><td colspan="2">Бүртгэлийн гэрчилгээний №<br><br>Certificate and Registration nomber:</td><td>Хаяг /Address:<br><br>Утас/Tel:<br>E-mail:</td></tr>
<tr><td rowspan="3">Банкин дахь харилцах болон хадгаламжийн дансны мэдээлэл</td><td>Төгрөгийн Данс</td><td>Банкны нэр/Bank name:<br><br>Банк дахь дансны№/Bank account No:</td></tr>
<tr><td rowspan="2">Валютын данс</td><td>Валютын нэр:<br><br>Банкны нэр/Bank name:<br><br>Банк дахь дансны№/Bank account No:</td></tr>
<tr><td>Валютын нэр:<br><br>Банкны нэр/Bank name:<br><br>Банк дахь дансны№/Bank account No:</td></tr>
</table>

Энэ дансанд холбогдох нөхцөл журамтай танилцаж түүнийг хүлээн зөвшөөрч байгааг баталгаажуулан гарын үсгээ зурав. By signing below I accept the terms and conditions of brokerage account.

| Д/д | Гарын үсэг зурах эрх бүхий хүний нэр Auhorized person’s name | Албан тушаал Occupation | Гарын үсэг зурах эрх олгосон тушаалын №,огноо Auhorized order’s number and date | Гарын үсгийн маяг Signature form | Тамга Stamp |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |

Нотариат батлав/To be notarized

**Харилцагчийн анхааралд/ For customers' attention**

1.Гарын үсэг зурах харилцагч нь данс, мөнгөний ба тооцооны баримтуудад гарын үсэг зурахдаа батлуулсан маягттайгаа тохируулан зурах үүрэг хүлээнэ. Customers shall be obliged to sign on check and all clearing and settlement documents provided by the ARD CAPITAL GROUP LLC.

2.Гарын үсэг зурах харилцагчийн эрх тогтмол байх эсэхийг "АРД КАПИТАЛ ГРУПП" ХХК-д тэмдэглэж өгнө. Тогтмол бол (тогтмол) гэсэн доогуур зур. Customers shall inform the ARD CAPITAL GROUP LLC of the authorization of persons to sign on check and wire transfer forms shall be permanent or temporary.

3.Түр байх бол доорхи хугацааг нөхөн бичнэ. If temporary please fill in the space below:

Гарын үсэг/Signature
Түр /Temporary Тогтмол/Permanent
200 оны сарын -ны өдрөөс
200 оны сарын -ныг хүртэл хүчинтэйд тооцно
Valed From……………../date/
United……………/date/

**"АРД КАПИТАЛ ГРУПП" ХХК-ийн ТЭМДЭГЛЭЛ**
**Note by ARD CAPITAL GROUP LLC**

Хүчинтэйд тооцож 2010 ны ..…. сарын..….ны өдөр хүлээн авлаа
Accepted on ……………. /date/
Баталгааг хүлээн авсан ажилтан..........................................
Received by........................

.

Ард капитал групп